



“ТЭТГЭВРИЙН УУГАН САН” ТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 10 сарын 27-ны өдөр

Дугаар 17/02

Улаанбаатар хот

“Ерөнхий нөхцөл”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн бус байгууллагын тухай хуулийн 11.1, Тэтгэврийн ууган сан ТББ-ын дүрмийн 4.8.8, Удирдах зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Удирдах зөвлөлийн 2010 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 10/01 тоот тогтоолоор батлагдаж, 2015 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 15/02 тоот тогтоолоор өөрчлөлт орсон Ерөнхий нөхцөлд дахин нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчилсэн Ерөнхий нөхцөлийг Хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолыг баталсантай холбогдуулан сангийн дүрэм, журам, мэдээлэлд өөрчлөлт оруулж, тогтоолыг 2018 оны 1 дүгээр сарын 01 өдрөөс үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ж.Хишигжаргал/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын нэг хувийг Хяналтын зөвлөлийн дарга /С.Төгсбилэг/-т хүргүүлсүгэй.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



О.ГАНЖОЛОО



ТЭТГЭВРИЙН УУГАН САН ("ТУС")

ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. ЗОРИЛГО

"Тэтгэврийн Ууган Сан"-гийн зорилго нь ажилтнуудын идэвх санаачлагатай, үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, тэднийг ирээдүйд тэтгэврийн нэмэлт орлого, хуримтлалтай болгоход оршино.

2. САНГИЙН ГИШҮҮН БОЛОХ

2.1. Сантай хамтран ажиллах гэрээ бүхий ажил олгогч /гишүүн байгууллага/- ийн үндсэн ажилтанд ажилтан гишүүн болох эрх үүснэ.

2.2. Гишүүн байгууллагын дараах ажилтнууд нь санд зөвхөн хувь гишүүнээр элсэх эрхтэй байна:

- Үндсэн бус гэрээт ажилтан
- Цалин хөлс олгогдож байгаа дадлагын оюутан, туршилтын хугацаанд ажиллаж буй ажилтан
- Байнгын бус гадаадын ажилтан

3. ХУРИМТЛАЛ БА НЭРИЙН ДАНС

3.1. Ажилтан сангийн гишүүн болсноор өөрийн болоод ажил олгогчийн зүгээс дор заасан нөхцөлийн дагуу хуримтлал үүсгэнэ:

Хуримтлалын нөхцөл	Ажилтнаас	Ажил олгогчоос
Эхлэх хугацаа	Сантай гэрээ байгуулсан өдрөөс эхлэн сангийн гишүүн болох бөгөөд гишүүн болсон сараас хуримтлал хийж эхэлнэ.	Ажилтаны Сантай гэрээ байгуулсан өдрөөр тооцон тухайн сараас хуримтлал хийж эхэлнэ.
Хэмжээ	Сар бүр үндсэн цалин буюу түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар суутгасны дараах дүнгээс /гарт олгох цалин/ Сан болон гишүүн байгууллага хоорондын гэрээнд заасан хувиар /эсхүл ажилтны өөрийн сонголтоор гишүүн байгууллагын зөвшөөрсөн хувь байж болно/ хуримтлал хийнэ.	Сан болон гишүүн байгууллага хоорондын гэрээнд заасан хувиар гишүүн ажилтны нэр дээр хуримтлал шилжүүлнэ.
Давтамж	Сар бүр	Сар бүр

3.2. Сан нь гишүүн тус бүрт гишүүний нэрийн дансыг нээж, сар бүрийн хуримтлалыг төвлөрүүлнэ.

3.3. Сангийн хувь гишүүний хуримтлал нь зөвхөн гишүүний өөрийн зүгээс хийх хуримтлал байна.

3.4. Сан гишүүний нэрийн дансанд хуримтлуулсан мөнгөн хөрөнгийг ханшийн болон бусад санхүү эдийн засгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд удирдаж, үнэ цэнийг урт хугацаанд хадгалах буюу өгөөж тооцох замаар хуримтлалыг өсгөнө.

4. ХУРИМТЛАЛ ОЛГОХ НӨХЦӨЛ, ХЭМЖЭЭ

4.1. Үндсэн нөхцөл

Ажилтан хуульд заасан тэтгэврийн насанд хүрснээр өөрийн нэрийн данс дахь хуримтлалыг бүрэн авна.

4.2. Хүндэтгэн үзэх нөхцөл

4.2.1. Тэтгэвэрт гарах наснаас өмнө нас барах	Ажилтны нэрийн дансан дахь нийт хуримтлалыг /ажилтны хувь, ажил олгогчийн хувь, сангийн өгөөж/ түүний хууль ёсны өв залгамжлагчид хуулийн дагуу олгоно.
4.2.2. Хөдөлмөрийн чадвараа алдах	Мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр ажилтан хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан буюу цаашид хөдөлмөр эрхлэх боломжгүй болсон нь тогтоогдсон бол түүний нэрийн дансан дахь нийт хуримтлалыг 100% олгоно.

4.3. Бусад нөхцөл

Бусад нөхцөлд ажил олгогчийн санаачлагаар, эсхүл ажилтны өөрийн санаачлагаар хөдөлмөрийн гэрээ дуусгавар болох, гишүүн өөрийн хүсэлтээр сангийн гишүүнчлэлээ цуцлах тохиолдлууд орно.

Хуримтал олгох нөхцөл	Ажил олгогчийн зүгээс хуримтлуулсан дүнгээс авах хэмжээ
4.3.1. Энэхүү Ерөнхий нөхцөлийн 4.3.2.-т зааснаас бусад үндэслэлээр хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон эсхүл гишүүн өөрийн хүсэлтээр сангийн гишүүнчлэлээ цуцалж байгаа бол;	Ажил олгогчийн хувийг энэхүү Ерөнхий нөхцөлийн 4.5.2-т заасан “Шатлал”-ын дагуу олгоно.
4.3.2. Хөдөлмөрийн тухай хуулийн 40.1.4, 40.1.5-д заасан үндэслэлээр ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцалсан бол;	Ажил олгогчийн хувийг “Шатлал”-ын дагуу олгох, бууруулж олгох, эсхүл эс олгох талаар ажил олгогчийн саналыг үндэслэн тогтооно.

4.4. Онцгой нөхцөл

4.4.1. гишүүн байгууллага Сантай байгуулсан гэрээг дуусгавар болгосноор;	Ажил олгогчийн саналыг авна. Уг санал нь ажил олгогчийн хуримтлалаас олгох хувийг тодорхой заах бөгөөд энэ нөхцөлийн 4.5.2.-д заасан Шатлалаас дордуулаагүй байна.
4.4.2. Сангийн Удирдах зөвлөлийн гишүүд санал нэгтгэйгээр Санг татан буулгах шийдвэр гаргаснаар;	

4.5 Хуримтлал олгох хэмжээ

4.5.1. Хуримтлал олгох бүх нөхцөлд гишүүнчлэлээс гарч буй тухайн жилийн өгөөжийг тооцохгүй.

4.5.2. Энэхүү Ерөнхий нөхцөлийн 4.3, 4.4 –т холбогдох заалтад дурдсанаар ажилтан гишүүний нэрийн дансанд ажил олгогчийн оруулсан хуримтлалаас олгох дүнг дараах шатлал /цаашид “Шатлал” гэх/-ын дагуу тогтооно.

Хуримтлал хийсэн хугацаа	Байгууллагын хувь олгох шатлал / ШАТЛАЛ/
1 жил хүртэл	Ажилтан зөвхөн өөрийн оруулсан хуримтлалыг авна.
1-2 жил хүртэл	Ажилтан зөвхөн өөрийн оруулсан хуримтлал, түүнд ногдох өгөөжийн хамт бүрэн авна.
3 ба түүнээс дээш жил хуримтлал хийсэн тохиолдолд	<ul style="list-style-type: none"> • Ажилтан өөрийн оруулсан хуримтлал, түүнд ногдох өгөөжийг бүрэн авна. • Ажил олгогчийн оруулсан хуримтлал ба түүнд ногдох өгөөжийн нийт дүнгээс дор дурдсан шатлалын дагуу олгоно: 3-4 жил (24 сар+1 хоногоос 48 сар) , 20%; 5-6 жил (48 сар+1 хоногоос 72 сар) , 40%; 7-8 жил (72 сар+1 хоногоос 96 сар) , 60%; 9-10 жил (96 сар+1 хоногоос 120 сар) , 80%; 11-ээс дээш жил (120 сар+1 хоног ба түүнээс дээш) , 100%;

5. ХУРИМТЛАЛЫГ ОЛГОХ ХЭЛБЭР

5.1. Үндсэн нөхцөлд гишүүний нэрийн дансан дахь хуримтлалыг дор дурьдсан хэлбэрүүдээр олгох ба аль нэгийг ажилтан өөрөө сонгох боломжтой.

- Нэг удаа бүрэн хэмжээгээр;
- Дансан дахь хуримтлалыг дуустал тодорхой хугацаанд тодорхой дүнгээр жил бүр.

5.2. Үндсэн нөхцлөөс бусад тохиолдолд гишүүний нэрийн дансан дахь хуримтлалыг нэг удаа бүрэн хэмжээгээр олгоно.

6. САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ, АЛДАГДАЛ

Ажилтны нэрийн дансан дахь хуримтлалыг хөрөнгө оруулалтын аргаар өсгөх ба хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны ашиг, алдагдалыг Сангийн нийт гишүүдэд хуваарилна.

7. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ АВАХ

7.1 Ажилтан өөрийн нэрийн дансны мэдээллийг электрон болон хэвлэмэл байдлаар авч болно. Энэ мэдээлэлд дор дурдсан зүйлсийг тусгана. Үүнд:

- Ажилтан болон ажил олгогчийн сар бүрийн хуримтлалын дүн;
- Нэрийн дансан дахь хуримтлалд ногдох хөрөнгө оруулалтын өгөөж /алдагдал/-ийн хэмжээ;
- Тухайн жилд дансанд хуримтлагдсан нийт дүн;
- Шаардлагатай бусад мэдээлэл

7.2 Ажилтан өөрийн дансны мэдээллийг тулган шалгаж, ямар нэг алдаа, зөрүү илэрсэн гэж үзвэл энэ тухай Сангийн холбогдох ажилтанд мэдэгдэж залруулах, тайлбар авах эрхтэй.

7.3 Сангийн ашиг алдагдал, үйл ажиллагааны талаарх мэдээллийг Сангийн гишүүдэд жилд нэг удаа хүргэнэ.

* * *